



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах,
түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэ журмыг 2016 оны 1 дүгээр улирлаас эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Тогтоол батлагдсантай холбогдуулан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам” батлах тухай Хорооны 2009 оны 232 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Батлагдсан журмын 11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалтын хэрэгжих хугацааг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хойшлуулсугай.
5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ц.Нацагдорж/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙНЭТГЭГЧ
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД



Санхүүгийн зохицуулах хорооны
2016 оны 70 дугаар тогтоолын хавсралт
2016 оны 11 сарын 11-ны өдрийн



**Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх
хуваарилах, түүнд хяналт тавих журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос Даатгалын тухай хуулийн 14.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж, ердийн даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-ийн даатгалын нөөц санг тооцоолох, бүрдүүлэх, хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгалын компани энэ журмаар зөвшөөрөгдсөн даатгалын нөөц сан байгуулах ангилал болон аргачлалаар даатгалын нөөц сангийн хэмжээг тооцох бөгөөд энэ нь даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээнээс үүсэх хариуцлагыг байнга хангахуйц хэмжээнд байна.

1.3. Даатгагчийн хувьд даатгалын нөөц сан байгуулах аргачлал нь энэ журмын 1.4 дэх заалтад зааснаас бусад нөхцөлд өөрчлөгдөхгүй.

1.4. Даатгагч учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг тооцоолохдоо ашигласан аргачлалаа өөрчлөх тохиолдолд тухайн аргачлалыг ашиглахаас 30-аас доошгүй хоногийн өмнө даатгагчийн хүсэлт ба актуарчийн саналыг Хороонд ирүүлж, мэдэгдэнэ. Санхүүгийн жилийн дундуур даатгалын учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан байгуулах аргачлалыг өөрчлөхийг хориглоно.

1.5. Даатгагч ямар ч цаг хугацаанд даатгалын нөөц санг тооцох боломжийг бүрдүүлсэн байна.

Хоёр. Журмын нэр томьёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. Даатгалын хураамжийн цэвэр орлого гэж даатгалын хураамжийн нийт орлогоос даатгалын хураамжийн буцаалт болон давхар даатгалын хураамжийн зардлыг хассан дүнг. /Даатгалын хураамжийн буцаалт гэж даатгалын гэрээ цуцлагдахад тухайн гэрээнд заасны дагуу даатгуулагчид буцаан төлөх даатгалын хураамжийг, Давхар даатгалын хураамжийн зардал гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгуулсны үндсэн дээр төлсөн ба төлөхөөр тооцсон төлбөрийг ойлгоно/;

2.1.2. Орлогод тооцсон хураамж гэж тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдсөн хураамжийн орлого буюу даатгалын хураамжийн цэвэр орлогоос орлогод

тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг хасч хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг нэмж тооцсон дүнг. /Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг тодорхойлно. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг тодорхойлно/;

2.1.3. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц гэж даатгалын гэрээний хугацаанаас хамааруулан орлогыг хувь тэнцүүлэн хуваарилсан буюу тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдөөгүй хураамжийн орлогыг;

2.1.4. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан гэж тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын тохиолдлын улмаас үүсэх даатгагчийн хүлээх хариуцлагын дүнг;

2.1.5. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан гэж даатгалын тохиолдол болсон тухай даатгагчид мэдэгдсэн бөгөөд даатгалын нөхөн төлбөр олгоогүй байгаа даатгалын нэхэмжлэлтэй холбогдох даатгагчийн хүлээх хариуцлагын дүнг;

2.1.6. Учирч болзошгүй хохирлын нөөц сан гэж даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээтэй холбогдон тайлант хугацаанаас хойш гарах нийт нөхөн төлбөр ба зардлын орлогод тооцоогүй хураамжаас давсан хэсгийг нөхөн төлөх даатгагчийн хүлээх хариуцлагын дүнг.

Гурав. Даатгалын нөөц сангийн ангилал

3.1. Даатгагчийн байгуулах даатгалын нөөц санг дараах байдлаар ангилна :

3.1.1. Даатгалын хураамжийн нөөц сан (Premium reserve):

3.1.1.1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН буюу англиар unearned premium reserve-UPR)

3.1.1.2. Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС буюу Unexpired risk reserve-URR)

3.1.2. Даатгалын нэхэмжлэлийн нөөц сан (Outstanding claims reserve):

3.1.2.1. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц (УБНХН буюу англиар Incurred but not reported-IBNR)

3.1.2.2. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС буюу англиар Reported but not Paid-RBNP)

Дөрөв. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг тооцох аргачлал

4.1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд “хувь тэнцүүлсэн арга”-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлно.

4.2. Даатгалын гэрээний хувьд орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг “хувь тэнцүүлсэн арга”-аар дараах томъёог ашиглан тооцно:

$$OTXNi = (ДНХi - ДБи) * \frac{Xi}{Ni}$$

, Үүнд:

$OTXNi$ = i дугаар даатгалын гэрээний орлогод тооцоогүй хураамжийн нөөц;

$ДНХi$ = i дугаар даатгалын гэрээний нийт хураамжийн орлого;

$ДБи$ = i дугаар даатгалын гэрээний даатгалын хураамжийн буцаалт

Xi = i дугаар даатгалын гэрээний хүчинтэй байх үлдсэн хугацаа/өдрөөр/ бөгөөд үүнийг гэрээний нийт хугацаанаас тухайн гэрээний тайлагналын өдөр хүртэл үргэлжилсэн хугацааг хасч тооцно;

Ni = i дугаар даатгалын гэрээний нийт үргэлжлэх хугацаа.

i - орлогод тооцоогүй хураамжийн нөөц тооцогдсон даатгалын гэрээний дугаар

4.3. Нийт орлогод тооцоогүй хураамжийн нөөц нь даатгалын гэрээ тус бүрээр байгуулсан орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийлбэртэй тэнцүү бөгөөд дараах томъёогоор тооцно.

$$OTXNt = \sum_{i=1}^n OTXNi$$

, Үүнд:

$OTXNi$ - t хугацаан дахь нийт орлогод тооцоогүй хураамжийн нөөц

n - орлогод тооцоогүй хураамжийн нөөц тооцсон даатгалын гэрээний нийт тоо

4.4. Буцаасан даатгалын хураамжийг хууль тогтоомжийн дагуу даатгалын гэрээний хугацаа дуусахаас өмнө даатгагчаас даатгуулагчид тухайн гэрээний үлдэх хугацаанд ногдуулан буцаан олгосон хураамжаар тодорхойлно.

4.5. Тайлагналын өдрөөр даатгалын хариуцлага гэрээний дагуу дууссан, эсхүл шинээр даатгалын хариуцлага нэмэгдсэн зэрэг шалтгаанаар Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн үлдэгдлийг тооцоолсны дараа тус нөөцийг бууруулах эсвэл нэмэгдүүлэх бол Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт дансаар тус нөөцийг нэмэгдүүлж эсвэл бууруулна.

Тав. Даатгалын нэхэмжлэлийн нөөц санг тооцох

5.1. Даатгагчийн нэхэмжлэлийн нөөц сан нь тайлагналын өдөр хүртэл мэдсэн боловч төлөөгүй эсхүл учирсан боловч мэдэгдээгүй нэхэмжлэлтэй холбоотой, энэ журмын 3.1.2.1, 3.1.2.2 дахь заалтад дурдсан нөөц сангуудын нийлбэртэй тэнцүү байна.

5.2. Даатгагч тайлагналын өдөр шийдвэрлэгдээгүй үлдсэн болон тайлагналын өдрөөс өмнөх хугацаанд үүссэн бөгөөд даатгагчид мэдэгдэхээр хүлээгдэж байгаа бүх нэхэмжлэлийг барагдуулахтай холбоотой нийт хариуцлагыг нарийвчлан тооцсон байна.

5.3. Энэ журмын 5.2-т дурдсан бүх нэхэмжлэлийг барагдуулах зардалд даатгуулагчид төлөхөөр тооцоолсон нөхөн төлбөрөөс гадна нөхөн төлбөрийн үнэлгээний зардал мөн хамаарна.

Зургаа. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг тооцох аргачлал

6.1. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, емэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна.

6.2. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн нийт хэмжээг дараах томъёогоор тооцно:

$$\text{МБТХНС} = (A + B - B + \Gamma) , \text{ Үүнд:}$$

МБТХНС = даатгалын гэрээ тус бүрээр тооцсон мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц.

A = тайлангийн үеэс /сар, улирал, жил байж болох/ өмнөх үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагчид мэдэгдсэн даатгалын өр төлбөрийн дүн /өмнөх тайлант үеийн Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн тухайн гэрээгээрх үлдэгдэл буюу тухайн хугацаанд хамаарах даатгалын нэхэмжилсэн хохирлын дүн дээр даатгагчид мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг нэмсэн дүнтэй тэнцэнэ/.

B = тайлангийн үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагч мэдсэн даатгалын өр төлбөрийн дүн, эдгээр нь компанийн нэхэмжлэлийн бүртгэлд орсон байна /даатгалын нэхэмжилсэн хохирлын дүн дээр даатгагч мэдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг нэмсэн дүнтэй тэнцэнэ/.

B = тайлангийн хугацаанд /зөвхөн тухайн улиралд/ барагдуулсан нэхэмжлэл.

Г = даатгалын хохирол үнэлгээний зардал, энэ нь дараах зүйлүүдийн нийлбэрээс бүрдэнэ:

(a) тайлангийн хугацааны эцэст шийдвэрлэгдээгүй байгаа нэхэмжлэлийн хохирол үнэлгээний зардлын дүн

(б) шаардлагатай бол хөндлөнгийн шинжээчийн зардлын дүнг нэмж тооцох.

6.3. Энэ журмын 6.2 дахь хэсэгт заасан “B”-ийн хувьд мэдсэн боловч нэхэмжлээгүй хохирлын дүнг тооцоход хүндрэлтэй тохиолдолд тооцоолол хийж буй өдрөөс өмнөх 2-оос дээш жилд ижил даатгалын зүйлд ижил төстэй тохиолдлуудаас ойролцоо хэмжээтэй учирсан хохирлуудын арифметик дундаж дүнгээр тухайн гэрээний даатгалын нийт

үнэлгээнээс хэтрэхгүйгээр, мөн хохирол үнэлгээний хамгийн оновчтой тооцоолсон дүнгээр нэмэгдүүлэн тооцно.

6.4. Шүүхийн маргаантай байгаа нэхэмжлэлийн хувьд Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг нэхэмжлэгчийн шаардлагын дүнгээр, даатгалын үнэлгээнээс хэтрэхгүйгээр тооцож нөөц байгуулна. Ийнхүү байгуулсан нөөцийг шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл нөөцөд хэвээр үлдээнэ. Нэмж байгуулах шаардлагатай гэж хэрэв даатгагч үзсэн бол мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөцийг нэмэгдүүлж болно.

6.5. Даатгагч нэхэмжлэл ирсэн огнооноос эхлэн нэхэмжлэлийг барагдуулах хүртэлх бүхий л мэдээллийг агуулсан Нэхэмжлэлийн бүртгэлийг үүсгэж, хөтөлнө.

6.6. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг даатгалын тохиолдол болсноор нэмэгдүүлэх эсвэл нөхөн төлбөрийг төлснөөр бууруулах бол тайлагналын өдөр Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт дансаар тус нөөц санг нэмэгдүүлж эсхүл бууруулна.

6.7. Даатгагч анхан шатны мэдээлэл дээр үндэслэн Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг байгуулсан бөгөөд нэмэлт мэдээлэл болон хөндлөнгийн байгууллагын шинжилгээг үндэслэн нөхөн төлбөрийн дүнг эцэслэн гарахад өмнөх байгуулсан нөөц сангийн дүнгээс их эсвэл бага байвал мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт дансаар тус санг нэмэгдүүлж эсхүл бууруулж болно.

Долоо. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг тооцох аргачлал

7.1. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистикт тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна.

7.2. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг тооцоход даатгагч хохирлын гурвалжны хөгжлийн аргуудыг ашиглана. Эдгээр арга нь актуар төсөөлөл, аргачлалд суурилах ба дараах шаардлагуудыг хангасан байна:

7.2.1. Хохирлын хөгжлийн гурвалжинг улирлын статистик тоон өгөгдлийг ашиглан үнэн зөв, бодитой тоон мэдээлэлд үндэслэн гаргах ба дор хаяж өмнөх 12 улирлын төлсөн нийт нөхөн төлбөр ба нөөц сангийн тоон мэдээллийг ашигласан байна.

7.2.2. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг тооцоолоход ашигласан статистик мэдээлэлд буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх төлбөрийг оруулахгүй.

7.2.3. Хохирол үнэлгээний зардлыг учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийн нийт дүнд оруулан тооцно.

7.2.4. Жигд бус тархалттай, их хэмжээний хохирлыг актуарч актуар тооцооллын шаардлагаар тохируулга хийж болох бөгөөд энэ талаар хавсралт-1д тусгасан байна.

7.3. Тооцоололд актуарчийн хийсэн тохируулга ихээхэн нөлөө үзүүлдэг учир актуарч уг нөөц сангийн тооцооллыг хийхэд ашиглагдсан таамаглал төсөөлөл, урьдчилсан нөхцөл болон бусад тохиргоог тодруулж энэхүү журмын хавсралт-1 д заавал тусгана.

7.4. Тайлагналын өдрөөр даатгалын хариуцлага гэрээний дагуу дууссан, шинээр даатгалын хариуцлага нэмэгдсэн эсвэл даатгалын тохиолдол болсныг даатгуулагч мэдэгдсэн зэрэг нөлөөг актуар тооцооллоор тооцсоноор Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг нэмэгдүүлэх эсвэл бууруулах шаардлагатай бол Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт дансаар тус нөөц санг нэмэгдүүлж эсвэл бууруулна.

Найм. Учирч болзошгүй хохирлын нөөц санг тооцох аргачлал

8.1. Учирч болзошгүй хохирлын нөөц санг даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

8.2. Учирч болзошгүй хохирлын нөөц санг /УБНХС/ даатгалын хэлбэр тус бүрийн хувьд дараах томъёо ашиглан байгуулна. Хаалтнаас гарах үр дүн сөрөг байвал энэхүү нөөцийг нэмэгдүүлэхгүй:

$$\text{УБНХС}_i = \left(\frac{\text{НТ}_i + \text{УАЗ}_i}{\text{ЦХ}_i - \Delta \text{ОТХН}_i} - 1.00 \right) * \text{ОТХН}_i$$

Үүнд:

НТ_i – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын нөхөн төлбөрийн цэвэр зардал/давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр орохгүй/ ба нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтийн нийлбэр/давхар даатгалын хэсэг орохгүй/,

УАЗ_i – i дугаар даатгалын хэлбэрийн /хэлбэрээр задлах эсэх/ үйл ажиллагааны зардал, үүнд: даатгалын гэрээний зардал, ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал, санхүүгийн зардал, бусад зардал хамаарна. Зардлуудыг хэлбэрээр задлах боломжгүй бол хэлбэр тус бүрийн орлогод тооцсон хураамжийг нийт орлогод тооцсон хураамжид харьцуулсан хувийн жинг үйл ажиллагааны зардлын дүнгээр үржүүлэн даатгалын хэлбэр тус бүрээрх зардлын задаргааг тооцож болно.

ЦХ_i – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын хураамжийн цэвэр орлого,

$\Delta \text{ОТХН}_i$ – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийт өөрчлөлт/хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг хасна/,

ОТХН_i – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын Орлогод тооцоогүй хураамжийн нийт нөөц.

8.3. Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн нийт хэмжээ нь даатгалын хэлбэр тус бүрээр байгуулсан учирч болзошгүй хохирлын нөөц сангуудийн нийлбэртэй тэнцүү бөгөөд дараах томъёогоор тооцно:

$$УБХНС_t = \sum_{i=1}^n УБХНС_i$$
, Үүнд:

УБХНС_t - учирч болзошгүй хохирлын нөөц сангийн нийт дүн.

8.4. Даатгагч энэ журмын 8.2 дахь заалтад дурдсан томъёоны хувьсагчдын ирээдүйн төсөөллийг тооцох статистик суурь мэдээлэл хангалттай бөгөөд тооцох боломжтой гэж үзвэл тэдгээрийг томъёоны харгалзах хэсгүүдэд орлуулан тооцоолж болно.

Ес. Нийт нөөц сангаас давхар даатгагчид ногдох хэсэг

9.1. Даатгалын нөөц сан дахь давхар даатгагчид ногдох хэсгийг даатгагч энэ журамд заасан харгалзах нөөц сантай адил аргачлалаар эсхүл давхар даатгалын гэрээний хэлбэр /хувь тэнцүүлсэн, хувь тэнцүүлээгүй, сайн дурын, албан журмын гэх мэт/, нөхцөлөөс хамааруулан өөрөөр тооцож болно.

9.2. Даатгагч нь давхар даатгагчид ногдох нөөц сангийн хэсгийг тооцохдоо даатгагчийн давхар даатгалын нэхэмжлэлийг барагдуулах чадавхи, давхар даатгагчаас буцаан төлүүлэх боломж зэргийг харгалзан үзнэ. Актуарч эдгээр үйл ажиллагаанд эрсдэл байгаа эсэхийг судалж, тооцох бөгөөд даатгалын нөөц сан байгуулахад давхар даатгалын эрсдэлийг хэрхэн тооцсон талаар актуарын тайланд тодруулан тусгасан байна.

9.3. Даатгагч, давхар даатгагч, дахин буюу ретро давхар даатгагчдын хооронд хийгдэж буй хөрөнгийн аливаа гүйлгээ нь бодитой, нотлогдсон байна.

9.4. Хойшлогдсон давхар даатгалын хураамж буюу давхар даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн тооцооллыг энэ журмаар заасан орлогод тооцоогүй хураамж тооцох аргачлалтай нэгэн адил аргачлалаар эсхүл хэрэв давхар даатгалын гэрээнд заасан бол тухайн нөхцөлөөр тус тус тооцоолно.

9.5. Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох УБМХНСангийн хэсэг буюу давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг давхар даатгуулсан даатгалын зүйлд учирсан даатгалын тохиолдолд хамаарах даатгалын гэрээ бүрийн хувьд байгуулна. Энэ нь давхар даатгалын гэрээнд заагдсан, давхар даатгагчаас олгох боломж бүхий мөнгөн дүнтэй тэнцүү байна.

9.6. Давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг даатгалын хэлбэр тус бүрээр давхар даатгалд шилжүүлсэн нөхөн төлбөрийн статистик мэдээлэлд тулгуурлан хэлбэр тус бүрийн хувьд дараах томъёогоор тооцно:

$$ДД_i = УБМХНС_t * \frac{НТ_{re}}{НТ_t}$$

, Үүнд:

ДД_i – даатгалын “i” хэлбэрээр учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн дүн;

УБМХНС_t – даатгалын “i” хэлбэрээр байгуулсан учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нийт нөөцийн хэмжээ;

НТ_{re} – даатгалын “i” хэлбэрийн хувьд давхар даатгалаас төлөгдсөн нөхөн төлбөр;

НТ_t – даатгалын “i” хэлбэрийн хувьд тайлангийн хугацаанд төлөгдсөн нийт нөхөн төлбөрийн хэмжээ.

Бүх хэлбэрээрх давхар даатгагчид ногдох учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангуудын нийлбэрээр давхар даатгагчид ногдох учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц санг тооцно.

$$ДД_t = \sum_{i=1}^n ДД_i$$

, Үүнд:

ДД_t = Бүх хэлбэрээрх давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн хэмжээ

Арав. Даатгалын нөөц сан тооцож бүрдүүлэхэд тавигдах шаардлага

10.1. Даатгагч бүр даатгалын нөөц сан тооцож, бүрдүүлэх Дотоод журамтай байна.

10.2. Энэхүү журмыг актуарч хянаж, даатгагчийн гүйцэтгэх удирдлага баталгаажуулна.

Ийнхүү баталснаас хойш 10 хоногт, хүчин төгөлдөр болохоос 10-аас багагүй хоногийн өмнө Хороонд хүргүүлнэ.

10.3. Хороо шаардлагатай гэж үзвэл Дотоод журамд өөрчлөлт оруулахыг шаардаж болно.

10.4. Даатгалын нөөц сан тооцож, бүрдүүлэх дотоод журамд дараах нөхцөлүүдийг заавал тусгасан байна:

10.4.1. Даатгалын нөөц сан тооцох суурь зарчим ба агуулга (нэр томъёоны тайлбар ба тодорхойлолт);

10.4.2. Дараах агуулгыг багтаасан даатгалын бүтээгдэхүүнүүдийн талаарх ерөнхийчиглэл:

10.4.2.1. даатгалын гэрээнүүдтэй холбогдох даатгалын эрсдэлүүд;

10.4.2.2. даатгалын хугацаа, даатгалын хураамж болон нөхөн төлбөр төлөх хугацаа;

10.4.2.3. даатгалын хураамжийн төлбөрийн зохицуулалт (жилээр, хагас жилээр, улирлаар, сараар, хуваарийн дагуу);

10.4.2.4. даатгалын буцаалтыг төлөх аргачлал;

10.4.2.5. даатгагчийн зардлын түвшин;

10.4.2.6. даатгалын нөөц сан тооцоолоход ашиглах нэмэлт арга, аргачлал, томьёо;

10.4.2.7. давхар даатгалын нөөц сан тооцоолох арга, аргачлал, томьёо.

10.5. Даатгагч даатгалын эрсдэлийн багцаа шилжүүлэх, эсхүл Хорооны өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг нөхцөлд даатгуулагчийн өмнө хүлээх эрсдэлийг бүрэн тайлагнах нөхцөлийг хангах зорилгоор календарийн аливаа өдрөөр даатгалын нөөц сангийн тайлан гаргах боломжийг бүрдүүлсэн байна.

10.6. Даатгагч дараах мэдээлэлд суурилан даатгалын нөөц санг бүрдүүлнэ:

10.6.1. даатгуулагчидтай байгуулсан даатгалын гэрээний бүртгэл;

10.6.2. даатгалын нөхөн төлбөрийн бүртгэл;

10.6.3. давхар даатгагчид даатгуулсан даатгалын гэрээний бүртгэл;

10.6.4. давхар даатгагчид даатгуулсан даатгалын гэрээний нөхөн төлбөрийн бүртгэл.

10.7. Энэ журмын 10.6 дахь заалтад дурдсан бүртгэлд дараах заалтуудыг дор хаяж тусгана:

- даатгалын гэрээний (даатгалын баталгааны) дугаар;
- даатгуулагчийн овог, нэр, регистр;
- даатгуулагчийн нас, хүйс, даатгалын хураамжид нөлөөлж болох бусад үзүүлэлт;
- гэрээ байгуулсан огноо, даатгалын хамгаалалт эхэлсэн ба дуусах огноо,
- даатгалын хугацаа, даатгалын гэрээний нөхцөл өөрчлөгдсөн огноо;
- даатгалын эрсдэлүүд;
- даатгалын үнэлгээ;
- даатгалын нийт хураамж;
- хүлээж авсан даатгалын хураамжийн хэмжээ, огноо, хуваарь;
- даатгалын гэрээ цуцалснаар буцаан төлсөн даатгалын хураамж, огноо;
- нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн өргөдлийн огноо, нэхэмжилсэн хэмжээ;
- даатгалын тохиолдлын огноо, даатгалын эрсдэл;
- мэдэгдсэн нэхэмжлэлийн өөрчлөлт, огноо;
- даатгалын нөхөн төлбөр олгосон огноо;
- даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан бол татгалзсан огноо.

Арван нэг. Даатгалын нөөц санд тавих хяналт

11.1. Даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд даатгалын бүх нөхөн төлбөр, хураамжийн буцаалт хийгдсэний дараах нөөц сангийн үлдэгдлээс Хорооноос томилсон актуарчийн актуар тооцооллын дагуу тохирох хэсгийг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Даатгагчдын холбооны тусгайлсан дансанд байршуулна.

11.2. Энэхүү журмын 11.1-д заасан тусгайлсан дансанд нөөц сангийн мөнгөн хөрөнгийг байршуулах болон зарцуулах үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулах бөгөөд хэрэгжилтэнд Хороо байнгын хяналт тавина.

11.3. Хороо даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавих бөгөөд даатгагчаас ирүүлсэн санхүүгийн тайланд тусгагдсан даатгалын нөөц санг тооцоолоход ашигласан материалыг энэхүү журмын хавсралт-1-д заасны дагуу шаардаж болно.

11.4. Энэхүү журмын 3.1.2.1, 3.1.2.2-т заасан даатгалын нөөц сангуудыг Хорооноос актуарын эрх авсан актуарч тооцоолох бөгөөд Хороо түүнд хяналт тавьж ажиллана.

11.5. Даатгагч нь жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан даатгалын нөөцийн сангийн үлдэгдлийг Хорооноос олгосон эрх бүхий актуарч эсхүл олон улсын мэргэжлийн холбоодоос олгосон Associate ба түүнтэй адилтгах түвшний болон түүнээс дээш эрхтэй актуарчаар баталгаажуулсан байна.

11.6. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг тооцоход ашиглах хохирлын гурвалжны суурь мэдээллийг үнэн зөв бүрдүүлсэн эсэх, актуарын тооцоололд ашиглахад тохиромжтой эсэхэд Хороо хяналт тавьж ажиллана. Өмнөх тайлант үед ашиглагдсан хохирлын гурвалжны мэдээллийг Хорооны зөвшөөрөлгүй өөрчлөхийг хориглоно.

11.7. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу Хороо хариуцлага хүлээлгэнэ.

Арван хоёр. Даатгалын нөөц сангуудийн үлдэгдлийн тохируулга

12.1. Энэхүү журмын 3.1.1.1-д заасан Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн эхний үлдэгдэл нь Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор баталсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.1.1-д заасан Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл байна.

12.2. Энэхүү журмын 3.1.2.1-д заасан Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн эхний үлдэгдэл нь Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор баталсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.1.2-д заасан Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэлтэй тэнцүү байна.

12.3. Энэхүү журмын 3.1.2.2-т заасан Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн эхний үлдэгдэл нь Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор баталсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.1.3-д заасан Нэхэмжилсэн хохирлын нөөц сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл байна.

12.4. Энэ журмын 3.1.1.2-т заасан Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн эхний үлдэгдэл нь Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор баталсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.1.4-т заасан Учирч болзошгүй хохирлын нөөц

сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдлийн 10 хувьтай тэнцүү байна. Тус сангийн бусад 90 хувийг Тусгай нөөц сангийн эхний үлдэгдлээр бүртгэнэ.

12.5. Энэ журмын 12.4 дэх хэсэгт заасан Тусгай нөөц санг даатгагч энэ журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 хүртэл жилийн хугацаанд балансын Нөхөн төлбөрийн нөөц сан хэсэгт тусгаж, Хорооны шийдвэрээр зарцуулж болно.

ooOoo—

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах түүнд хяналт тавих журам"-ын хавсралт-1

Даатгалын нөөц сангийн актуар тайлан

Даатгалын нөөц сангийн актуар тайлан нь техник тооцоолол болон холбогдох тайлбарыг агуулсан байх бөгөөд хөндлөнгийн актуарч, хянан шалгагч тооцооллыг үнэн зөв эсэхийг дүгнэхэд хангалттай мэдээлэл агуулсан байна.

Актуар тайлангийн агуулга дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлангийн зорилго, хамрах хүрээ, хязгаарлалт:

- Зорилго
- Тайлангийн хамрах хугацаа, даатгалын бүтээгдэхүүн ба хэлбэрийн мэдээлэл
- Тайлан гаргах цаг хугацааны болон бусад хязгаарлалт, бусад мэдээлэл

2. Үндэслэл:

- Тооцоололд тавигдах нийтлэг үндэслэл болон өмнөх үеийн тооцооллоос өөрчлөгдсөн болон нэмэгдсэн зүйлийн талаарх мэдээлэл.

3. Ашиглагдсан мэдээлэл:

- Даатгалын нөөц санг тооцоолоход ашиглагдсан компанийн түүхэн мэдээлэл, мэдээллийн эх үүсвэр, хэрхэн баталгаажуулсан болон ямар хугацааны мэдээлэл ашиглагдсан талаарх тайлбарыг тусгах.

4. Аргачлалууд:

• Даатгалын нөөц санг тооцоолох үндсэн аргачлалуудаас сонгосон аргачлал, уг аргачлалыг сонгох шалтгаан, үндэслэлийн хамт тусгах. Аргачлалуудыг хавсарч ашиглах тохиолдолд мөн үндэслэлээ тайлбарлах.

5. Дүн шинжилгээ, хэлэлцүүлэг:

• Бүх ашиглагдсан тооцоолол, мэдээллийн тохируулга болон бусад зүйл дээр ашиглагдсан таамаглал, тохиргоо, өөрчлөлтүүдийн тайлбарыг дэлгэрэнгүй тусгах. Жишээ нь, инфляцийн нөлөөг тооцоололдоо оруулж байгаа тохиолдолд ашиглагдах инфляцийн мэдээллийг эх үүсвэрийн хамт дурдаж, хэрхэн тооцооноо харуулах.

6. Хавсралт, бусад файлуудтай холбогдох дугаарлалт

• Актуарч тайландаа тооцоололд ашиглагдсан түүхэн мэдээлэл болон бусад холбогдох файлуудаа хавсаргах бөгөөд эдгээрийг ойлгомжтой хэлбэрээр тайланд тусгасан байх.